



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/72

Баянбулаг

Г Хууль бус ан агнуур болон тарваган тахал
өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга
хэмжээ зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2.10, Аймгийн Засаг даргын 2022 оны А/514 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчны гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, агнахыг хориглосон амьтныг хууль бусаар агнах, тээвэрлэх, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн худалдаалахыг бууруулах, хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл Хууль бус ан агнуур болон Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг эрүүл мэндийн төв (М.Даваахүү), Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Батхонгор), хэсгийн төлөөлөгч (Цагдаагийн ахлах дэслэгч Х.Наранбаатар), Эрэн хайх аврах бүлгийн дарга (дэслэгч Э.Мөнгөн-Оргил), Байгаль хамгаалагч (Т.Нямжанцан), идэвхтэн байгаль хамгаалагч нарт тус тус үүрэг болгосугай.

2. Сумын хэмжээнд "Хяналт шалгалт, хөдөлгөөнт эргүүл зохион байгуулах хуваар"-ийг хавсралтаар баталсугай.

3. Хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг холбогдох зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Амгаланбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Н.ГАНСҮХ



642201069

Баянцаган сумын Засаг даргын 2026 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 17 дугаар захирамжийн хавсралт



**ХУУЛЬ БУС АН АГНУУР, ТАРВАГАН ТАХАЛ ЭВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ**

| Д/д | Эргүүл хяналт хийх газар нутгийн нэр | Хөдөлгөөн эргүүл хийх хугацаа | Хамтран ажиллах байгууллага | Хариуцан зохион байгуулагч |
|-----|--------------------------------------|-------------------------------|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Гичгэнэ уул | VIII/20-IX/01 | Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг, Эрэн хайх аврах бүлэг, идэвхтэн байгаль хамгаалагч Ц.Бат-Идэр | Байгаль хамгаалагч Т.Нямжанцан |
| 2 | Баянцагаан уул | VIII/10-VIII/20 | Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг, Эрэн хайх аврах бүлэг, идэвхтэн байгаль хамгаалагч Б.Баярт-Од | Байгаль хамгаалагч Т.Нямжанцан |
| 3 | Цэцэн уул | IX/01-IX/15 | Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг, Эрэн хайх аврах бүлэг, идэвхтэн байгаль хамгаалагч Ц.Цэрэнжав | Байгаль хамгаалагч Т.Нямжанцан |
| 4 | Сумын төвийн орох, гарах пост | VIII/10-X/10 | Цагдаагийн хэсэг, Эрэн хайх аврах бүлэг | Хэсгийн төлөөлөгч Х.Наранбаатар Бүлгийн дарга Э.Мөнгөн-Оргил |